

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2026/259/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Аудитор: Г.Батбилэг Утас: 261628 Цахим хаяг: batbilegg@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	18
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	21
5.2 Албан шаардлага.....	21
5.3 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/309
танай _____-ны № _____-т

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
М.БАЯРАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд 2023-2025 онд 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй ипотекийн зээл авсан нийт 5173 өрхийн 8,025,574.6 мянган төгрөгийн хүүгийн татаас, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд заасан хүүгийн өгөөж болон хөрөнгө оруулалтын өгөөжийн зөрүү 35,471,917.1 мянган төгрөг, нийт 43,497.491.7 мянган төгрөгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны урсгал зардал дээр төлөвлөн баталж, Монгол банк болон Сангийн яамны хоорондын тооцоог үндэслэн Монгол банканд шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус яамны удирдлагаас “Цагаан хуаран консалтинг” ХХК болон “Бэрэн групп” ХХК нь “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний үүргээ 13 жилийн хугацаанд биелүүлэхгүй байгаад Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монгол Үндэсний арбитра

нэхэмжлэл гаргаснаар тайлант онд Монголын олон улсын арбитрын 343 дугаар шийдвэрээр “Цагаан хуаран консалтинг” ХХК-аас 36,348,591.8 мянган төгрөг, Монголын олон улсын арбитрын 492 дугаар шийдвэрээр “Бэрэн групп” ХХК-аас 230,028,100.4 мянган төгрөг, нийт 266,376,692.1 мянган төгрөгийг төсөвт нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Засгийн газрын 2025 оны 07 тогтоолоор яамны бүтцэд өөрчлөлт орсон бөгөөд ажлаас чөлөөлөгдсөн 8 албан тушаалтанд 49,068.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олгосон, шинээр 25 албан тушаалтныг албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилсноос 12 түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг ХББОСЯ-ны харьяалалгүй байгууллагаас томилж төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон зэрэг дэвийн нэмэгдэлд нийт 37,958.6 мянган төгрөгийн олгосон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэргээгээр/

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,611,944,249.79	6,980,075,526.85
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,830,389,211.56	2,688,092,436.09
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,830,389,211.56	2,688,092,436.09
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,830,389,211.56	2,688,092,436.09
31210	Төгрөг	75,000,754.00	
31220	Гадаад валют	2,755,388,457.56	2,688,092,436.09
31221	Төрийн сангийн харилцах	2,755,388,457.56	2,688,092,436.09
33	АВЛАГА	13,699,456,283.23	4,264,683,645.76
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,883.23	206,591.76
33500	Бусад авлага	13,699,453,400.00	4,264,477,054.00
33510	Байгууллагаас авах авлага	13,689,425,000.00	4,254,448,654.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	10,028,400.00	10,028,400.00
34	УРЬДЧИЛГАА	39,765,000.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	39,765,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	42,333,755.00	27,299,445.00
35400	Хангамжийн материал	42,333,755.00	27,299,445.00
35410	Бичиг хэргийн материал	4,963,745.00	6,403,920.00
35430	Сэлбэг хэрэгсэл	313,500.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	37,056,510.00	20,895,525.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	984,305,637.39	614,844,347.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	984,305,637.39	614,844,347.36
39200	Биет хөрөнгө	976,471,011.05	613,725,890.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	250,324,000.00	250,324,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(124,005,063.01)	(149,037,462.97)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	543,433,406.28	509,645,284.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(110,283,589.50)	(240,705,416.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	241,687,512.85	213,765,228.19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,108,694.50)	(75,634,023.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	239,549,127.22	238,662,678.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,125,688.29)	(133,294,397.77)
39300	Биет бус хөрөнгө	7,834,626.34	1,118,456.91
39301	Програм хангамж	6,533,483.27	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,088,913.88)	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,716,000.00	12,716,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(10,325,943.05)	(11,597,543.09)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	17,596,249,887.18	7,594,919,874.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,755,388,457.76	2,688,092,436.09
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,755,388,457.76	2,688,092,436.09
41300	Өглөг	2,755,388,457.76	2,688,092,436.09
41360	Бусад өглөг	2,755,388,457.76	2,688,092,436.09
41361	Байгууллагад төлөх өглөг	2,755,388,457.76	2,688,092,436.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,840,861,429.42	4,906,827,438.12
51	Засгийн газрын хувь оролцоо	14,840,861,429.42	4,906,827,438.12
51100	Засгийн газрын оруулсан капитал	324,390,884.93	324,390,884.93
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	324,390,884.93	324,390,884.93
51200	Хуримтлагдсан үр дүн	14,516,470,544.49	4,582,436,553.19
51210	Өмнөх үеийн үр дүн	175,000,667.47	5,036,612,444.49
51220	Тайлант үеийн үр дүн	14,341,469,877.02	(454,175,891.30)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	17,596,249,887.18	7,594,919,874.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэргээгээр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	33,100,854,156.21	54,766,342,489.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	569,503,105.20	54,766,342,489.60
120	Нийтлэг татварын бус орлого	569,503,105.20	10,685,400.00
120009	Бусад орлого	75,000,754.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	494,482,551.20	10,685,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,800.00	0.00
122	Тусламжийн орлого	0.00	54,755,657,089.60
1221	Хандив тусламж /дотоод/	0.00	54,755,657,089.60
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	53,710,163,453.74
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.00	53,710,163,453.74
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,045,493,635.86
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	172,847,715.36
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	872,033,120.50
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	612,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,531,351,051.01	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,414,482,261.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,414,482,261.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,116,868,790.01	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,094,185,469.92	0.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,022,683,320.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,759,384,279.19	50,643,526,626.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,759,384,279.19	50,643,526,626.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,833,418,412.59	6,565,223,115.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,458,771,462.04	3,945,167,135.11
210101	Үндсэн цалин	2,124,313,642.52	2,403,571,020.38
210102	Нэмэгдэл	670,313,889.52	669,170,314.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	401,200,000.00	546,176,000.00
210104	Урамшуулал	259,943,930.00	326,249,800.00
210105	Гэрээт ажлын хөлс	3,000,000.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	430,128,410.32	498,983,182.25
210201	Тэтгэврийн даатгалын зардал	290,497,772.63	337,100,072.60
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	34,278,937.96	39,617,150.39
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	22,978,696.37	25,602,107.10
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,386,842.60	19,050,596.91
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	65,986,160.76	77,613,255.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,655,500.00	40,884,603.00

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	13,655,500.00	40,884,603.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,996,700.70	91,606,614.98
210401	Бичиг хэрэг	23,099,400.00	18,935,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,625,660.00	5,781,888.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,161,040.70	33,586,426.98
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,110,600.00	33,302,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	282,448,550.00	74,194,808.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	496,400.00	537,900.00
210604	Урсгал засвар	281,952,150.00	73,656,908.00
2107	Томилолт, зочны зардал	73,266,094.20	52,174,385.00
210702	Дотоод албан томилолт	73,266,094.20	52,174,385.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,893,711,710.54	553,578,905.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,874,898,382.34	537,389,034.36
210803	Даатгалын үйлчилгээ	2,094,928.80	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,952.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,018,127.40	2,817,000.00
210807	Газрын төлбөр	-	988,951.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,556,320.00	12,383,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,615,439,984.79	1,308,633,482.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,462,382,926.97	955,889,236.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,601,000.00	5,945,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,456,057.82	346,798,345.60
212	ТАТААС	0.00	43,497,491,653.74
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	43,497,491,653.74
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	43,497,491,653.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	925,965,866.60	580,811,857.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	131,486,609.13
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	131,486,609.13
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	131,486,609.13
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.00	130,873,809.13
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал\	0.00	612,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	449,891,752.44	449,325,248.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	59,020,620.00	99,043,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	284,900,000.00	304,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,971,132.44	46,282,248.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	476,074,114.16	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	476,074,114.16	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	19,341,469,877.02	4,122,815,862.93
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,000,000,000.00	4,576,991,754.23
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	4,500,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	76,991,754.23
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(5,000,000,000.00)	(4,576,991,754.23)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	14,341,469,877.02	(454,175,891.30)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэрэгээр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	32,692,473,734.92	54,755,657,089.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,000,754.00	54,755,657,089.60
120	Нийтлэг татварын бус орлого	75,000,754.00	612,800.00
120009	Бусад орлого	75,000,754.00	612,800.00
122	Тусламжийн орлого	0.00	54,755,044,289.60
1221	Хандив тусламж /дотоод/	0.00	54,755,044,289.60
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.00	53,710,163,453.74
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.00	53,710,163,453.74
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,044,880,835.86
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	172,847,715.36
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	872,033,120.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,617,472,980.92	0.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,414,482,261.00	0.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,414,482,261.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,202,990,719.92	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,094,185,469.92	0.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,108,805,250.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,449,136,550.84	50,476,637,958.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,449,136,550.84	50,476,637,958.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,427,020,354.33	6,353,452,694.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,377,071,435.86	3,926,371,545.77
210101	Үндсэн цалин	1,814,930,825.09	2,235,655,719.62
210102	Нэмэгдэл	930,306,286.59	780,601,091.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	400,054,261.83	534,737,283.46
210104	Урамшуулал	229,358,562.35	375,377,451.17
210105	Гэрээт ажлын хөлс	2,421,500.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	430,197,266.14	517,982,480.12
210201	Тэтгэврийн даатгалын зардал	291,407,819.16	352,371,298.43
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	34,250,188.23	41,315,082.17
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	19,876,636.62	21,488,079.87
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	18,733,958.15	20,508,827.92
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	65,928,663.98	82,299,191.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,655,500.00	42,420,373.00
210304	Байрны түрээс	13,655,500.00	42,420,373.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,975,480.70	91,418,339.98
210401	Бичиг хэрэг	25,688,480.00	20,146,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,625,660.00	5,781,888.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	31,161,040.70	32,185,851.98

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,500,300.00	33,303,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	475,090,550.00	73,165,190.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,352,400.00	3,991,650.00
210604	Урсгал засвар	464,738,150.00	69,173,540.00
2107	Томилолт, зочны зардал	73,266,094.20	52,174,385.00
210702	Дотоод албан томилолт	73,266,094.20	52,174,385.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,958,325,100.46	723,659,450.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,939,420,752.26	708,380,979.72
210803	Даатгалын үйлчилгээ	2,094,928.80	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,952.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,018,127.40	1,457,000.00
210807	Газрын төлбөр	0.00	988,951.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,647,340.00	12,832,520.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,030,438,926.97	926,260,929.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,010,837,926.97	920,315,029.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,601,000.00	5,945,900.00
212	ТАТААС	0.00	43,497,491,653.74
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	43,497,491,653.74
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.00	43,497,491,653.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,022,116,196.51	625,693,611.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	176,368,363.13
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	176,368,363.13
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	0.00	176,368,363.13
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.00	130,873,809.13
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогдтооцох төвлөрүүлгийн зардал	0.00	612,800.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	0.00	44,881,754.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	459,920,152.44	449,325,248.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	69,049,020.00	99,043,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	284,900,000.00	304,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,971,132.44	46,282,248.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	562,196,044.07	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	476,074,114.16	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	86,121,929.91	0.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	44,881,754.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	44,881,754.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,243,337,184.08	4,279,019,130.64
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	219,729,300.00	26,867,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	219,729,300.00	26,867,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	219,729,300.00	26,867,600.00

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	219,729,300.00	26,867,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(219,729,300.00)	(26,867,600.00)
14	Бусад эх үүсвэр	5,520,118.54	105,551,693.89
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,520,118.54	105,551,693.89
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,000,000,000.00	4,500,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	5,000,000,000.00	4,500,000,000.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(4,994,479,881.46)	(4,394,448,306.11)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(970,871,997.38)	(142,296,775.47)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,801,261,208.94	2,830,389,211.56
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,755,388,457.56	2,688,092,436.09

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэрэгээрл

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	0.00	175,000,667.47	499,391,552.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	0.00	175,000,667.47	499,391,552.40
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	14,341,469,877.02	14,341,469,877.02
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	0.00	14,516,470,544.49	14,840,861,429.42
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	324,390,884.93	0.00	14,516,470,544.49	14,840,861,429.42
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(9,479,858,100.00)	(9,479,858,100.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	324,390,884.93	0.00	5,036,612,444.49	5,361,003,329.42
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(454,175,891.30)	(454,175,891.30)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	324,390,884.93	0.00	4,582,436,553.19	4,906,827,438.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэргээгээр

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	73,388,055,400.00	53,579,289,644.61	19,808,765,755.39	73.0
12	Татварын бус орлого	73,388,055,400.00	53,579,289,644.61	19,808,765,755.39	73.0
122	Тусламжийн орлого	73,388,055,400.00	53,579,289,644.61	19,808,765,755.39	73.0
122005	Төсвөөс санхүүжих	73,388,055,400.00	53,579,289,644.61	19,808,765,755.39	73.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,388,055,400.00	53,579,289,644.61	19,808,765,755.39	73.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,888,055,400.00	49,079,289,644.61	19,808,765,755.39	71.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,571,404,900.00	5,141,977,742.87	429,427,157.13	92.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,989,440,200.00	3,926,371,545.77	63,068,654.23	98.4
210101	Үндсэн цалин	2,394,108,800.00	2,235,655,719.62	158,453,080.38	93.4
210102	Нэмэгдэл	827,881,100.00	780,601,091.52	47,280,008.48	94.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	376,130,700.00	534,737,283.46	(158,606,583.46)	142
210104	Урамшуулал	391,319,600.00	375,377,451.17	15,942,148.83	95.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	524,807,000.00	517,982,480.12	6,824,519.88	98.7
210201	Тэтгэврийн даатгал	356,770,200.00	352,371,298.43	4,398,901.57	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	41,964,600.00	41,315,082.17	649,517.83	98.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,259,200.00	21,488,079.87	(228,879.87)	101
210204	Ажилгүйдлийн даатгал	20,945,500.00	20,508,827.92	436,672.08	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	83,867,500.00	82,299,191.73	1,568,308.27	98.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,421,100.00	42,420,373.00	727.00	100.0
210304	Байрны түрээс	42,421,100.00	42,420,373.00	727.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	100,455,100.00	98,818,339.98	1,636,760.02	98.4
210401	Бичиг хэрэг	19,230,100.00	20,146,800.00	(916,700.00)	105.0
210402	Тээвэр, шатахуун	5,927,300.00	5,781,888.00	145,412.00	97.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,379,400.00	32,185,851.98	(2,806,451.98)	110.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	45,918,300.00	40,703,800.00	5,214,500.00	88.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,632,800.00	92,632,790.00	10.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,459,300.00	23,459,250.00	50.00	100.0
210604	Урсгал засвар	69,173,500.00	69,173,540.00	(40.00)	100.0
2107	Томилолт, зочны зардал	76,457,900.00	52,174,385.00	24,283,515.00	68.2
210702	Дотоод албан томилолт	76,457,900.00	52,174,385.00	24,283,515.00	68.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	689,974,700.00	357,350,020.00	332,624,680.00	51.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	653,618,300.00	342,071,549.00	311,546,751.00	52.3

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	5,179,000.00	0.00	5,179,000.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,000.00	0.00	224,000.00	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,400.00	0.00	39,400.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,486,100.00	1,457,000.00	3,029,100.00	32.5
210807	Газрын төлбөр	3,095,000.00	988,951.00	2,106,049.00	32.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	23,332,900.00	12,832,520.00	10,500,380.00	55.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,216,100.00	54,227,809.00	988,291.00	98.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,270,200.00	48,281,909.00	988,291.00	98.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,945,900.00	5,945,900.00	0.00	100.0
212	ТАТААС	62,861,404,500.00	43,497,491,653.74	19,363,912,846.26	69.2
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,861,404,500.00	43,497,491,653.74	19,363,912,846.26	69.2
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,861,404,500.00	43,497,491,653.74	19,363,912,846.26	69.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	455,246,000.00	439,820,248.00	15,425,752.00	96.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	455,246,000.00	439,820,248.00	15,425,752.00	96.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	90,551,000.00	89,538,000.00	1,013,000.00	98.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	314,840,500.00	304,000,000.00	10,840,500.00	96.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,854,500.00	46,282,248.00	3,572,252.00	92.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,500,000,000.00	4,500,000,000.00	0.00	100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	4,500,000,000.00	4,500,000,000.00	0.00	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	180	174	6	96.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	90	86	4	95.6
620001	Удирдах ажилтан	18	18	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	72	68	4	94.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	88	86	2	97.7
650001	Төрийн захиргааны албан хаагч	79	76	3	96.2
650003	Ажлын албаны албан хаагч	3	3	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	4	5	(1)	125.0
650011	Улс төрийн албан хаагч	2	2	0	100.0
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1	0	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Итгэрэгээр!

Дансны код	Үзүүлэлт	Тайлант он	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,044,880,835.86	1,044,880,835.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,044,880,835.86	1,044,880,835.86
122	Тусламжийн орлого	1,044,880,835.86	1,044,880,835.86
1221	Хандив тусламж /дотоод/	1,044,880,835.86	1,044,880,835.86
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,044,880,835.86	1,044,880,835.86
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	172,847,715.36	172,847,715.36
350013	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	872,033,120.50	872,033,120.50
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,044,880,835.86	1,044,880,835.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,044,880,835.86	1,044,880,835.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,044,880,835.86	1,044,880,835.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,847,715.36	172,847,715.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,847,715.36	172,847,715.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	872,033,120.50	872,033,120.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	872,033,120.50	872,033,120.50

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам “иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлсэн “ногоон, хүн төвтэй” хот, суурин газрыг хөгжүүлж, хүртээмжтэй барилга, орон сууц, инженерийн дэд бүтцээр хангахад оршино” гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлага, хүний нөөцийн манлайллыг хангах, эрх зүйн тусалцаа үзүүлэх, салбарын олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, салбарын суурь судалгаа, статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;
- Салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх бодлого боловсруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагаар хангах;
- Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтыг боловсруулах, хот дахин төлөвлөлтийг хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, зохицуулалтыг боловсруулах, хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого, зохицуулалтаар хангах, салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- Хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах талаар салбарын хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тогтолцоог хэрэгжүүлэх, удирдлагаар хангах зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 25 дугаар тогтоолоор яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, орон тоог баталсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна.

- Засгийн газрын тухай хууль;
- Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан “Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай”

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тус яамны 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн бөгөөд баталгаажсан аудитын тайлан, зөвлөмж, ирүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,001,330.0 мянган төгрөгөөр буюу 2.3 дахин буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	2,830,389.2	2,688,092.4	(142,296.8)
Авлага	13,699,456.3	4,264,683.7	(9,434,772.0)
Урьдчилгаа	39,765.0	0.0	(39,765.0)
Бараа материал	42,333.8	27,299.4	(15,034.3)
Үндсэн хөрөнгө	984,305.6	614,844.3	(369,461.3)
Нийт хөрөнгө	17,596,249.9	7,594,919.9	(10,001,330.0)
Өр төлбөр	2,755,388.5	2,688,092.4	(67,296.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	14,840,861.4	4,906,827.4	(9,934,034.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,596,249.9	7,594,919.9	(10,001,330.0)

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,688,092.4 мянган төгрөгт хүрч, 142,296.8 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн сангийн 201900029402 тоот ам.долларын харилцах дансанд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Дархан хотын бохир усны менежментийн МОН-3244/3245 төсөл”-ийн гүйцэтгэлийн баталгааны байршуулсан хөрөнгөөс уг төсөлд түр горимоор нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлт, албан татварын зардалд зарцуулсантай холбоотой;

Авлагын дансны үлдэгдэл 4,264,683.7 мянган төгрөгт хүрч, өмнөх оноос 9,434,772.0 мянган төгрөгөөр буурсан нь “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-тай байгуулсан 2024/277 дугаартай хяналт хэрэгжүүлэх гэрээний гүйцэтгэл 9,299,858.1 мянган төгрөгөөр

буурсан, Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар 180,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан нь голлон нөлөөлсөн;

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй болсон нь Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын 2024 оны 145 дугаар тушаалын дагуу “Үндэсний орон сууцжуулалтын тухай” хуулийн төсөлд авах зөвлөмж үйлчилгээ авах 2024/159 дугаартай гэрээ, “Хот байгуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөлд зөвлөх үйлчилгээ авах 2024/192 дугаартай гэрээ, “Орон сууцны тухай” хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөлд зөвлөх үйлчилгээ авах 2024/193 дугаартай гэрээнүүдийн урьдчилгаа 39,765.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг 2025 онд тухайн гэрээнүүд хэрэгжиж, гэрээ дүгнэсэн тул урьдчилж гарсан зардлыг бууруулсан;

Бараа материалын дансны үлдэгдэл 27,299.4 мянган төгрөгт хүрч, 15,034.3 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/106 дугаар тушаалаар бараа материалын дансанд бүртгэлтэй байсан 10,685.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлсэн, Төрийн нарийн бичгийн даргын 6,060.4 мянган төгрөгийн бараа материалыг акталсан нь нөлөөлсөн;

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 614,844.3 мянган төгрөг болж 369,461.3 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар бараа материалын данснаас 10,685.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 26,867.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 396 дугаартай “үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 106,683.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хассан, тайлант хугацаанд 346,798.3 мянган төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэн нь нөлөөлсөн;

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,688,092.4 мянган төгрөгт хүрч, 67,296.0 мянган төгрөгөөр буурсан нь дээрх “Дархан хотын бохир усны менежментийн МОН-3244/3245 төсөл”-ийн хүрээнд гүйцэтгэлийн баталгааны байршуулсан хөрөнгөөс тоног төхөөрөмжийн гаалийн бүрдүүлэлт, албан татварын 172,847.7 мянган төгрөгийн төлбөрийг барагдуулсантай холбоотой;

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны өдөр тутмын албан хэрэгцээнд Microsoft 365 программын business standart, Kaspersky endpoint security for business select антивирусын лицензүүд болон санхүүгийн үйл ажиллагаанд Acolous программын лицензийг эзэмшдэг бөгөөд цахим дэлгүүрээс лицензийн 48,636.8 мянган төгрөг, программын сунгалтад 1,932.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яам 2025 оны төсвийн төсөлд нийт зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 65,981,087.7 мянган төгрөгөөр тооцон улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 62,835,975.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бараа үйлчилгээний зардал, эргэж төлөгдөх зээлийг 54,381,816.5 мянган төгрөгөөр бууруулснаар нийт 8,454,158.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 74,435,246.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал: урсгал зардлаас эргэж төлөгдөх зээл 47,800,000.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 314,025.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 6,267,957.1 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 96,654.4 мянган төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 36.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, урсгал зардлаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28,608.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 8,441.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн ба төлөвлөөгүй хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 63,150,000.0 мянган төгрөгийг нэмсэн байна.

Засгийн газраас төрийн ажил үйлчилгээг цахимд шилжүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх инновацыг салбар бүрд нэвтрүүлэх, иргэдэд хүрэх төрийн үйлчилгээний чанарыг бууруулалгүй бүх шатны төрийн байгууллагуудын тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримтлан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, төсвийг 1,047,190.8 мянган төгрөгөөр бууруулж, 73,388,055.4 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага” хөтөлбөрийн 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсныг цалин хөлсний нэмэгдэл, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал хүрэлцэхгүйгээс шалтгаалан тайлант хугацаанд зарлагын эдийн засгийн ангилал хооронд дээд шатны байгууллагын зөвшөөрлөөр 2 удаа, нийт 175,000.0 мянган төгрөгийн зарлагын зохицуулалтыг хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 73,388,055.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 5,581,798.0 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлд 4,500,000.0 мянган төгрөг, Монгол банканд хувийн хэвшлийн байгууллагад олгох 43,497,491.6 мянган төгрөгийг орон сууцны зээлдэгч нарын төлбөрт шилжүүлэн, зарцуулаагүй 130,873.8 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 53,579,289.6 мянган төгрөг буюу 73.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 429,427.2 мянган төгрөг, урсгал шилжүүлгийг 19,379,338.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь Засгийн газраас тэвчиж болох зардлыг хэмнэх зарчмыг баримтлан Сангийн яамны Төрийн сангийн газраас зардлын эх үүсвэр бүрэн санхүүжигдээгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсвийг төсвийн зарлагын 71509 кодтой “Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй” хөтөлбөрийн хүрээнд доорх зориулалт, арга хэмжээгээр зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Зориулалт болон арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	4,917,786.6	4,799,906.2	117,880.4	97.6
2	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	204,079.1	202,052.2	2,026.9	99.0
3	80404 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	62,861,404.5	43,497,491.7	19,363,912.8	69.2
4	80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж	314,840.5	304,000.0	10,840.5	96.6

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	140,405.5	135,820.2	4,585.2	96.7
6	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	449,539.2	140,019.3	309,519.9	31.1
7	83117	Орон сууцжуулах	4,500,000.0	4,500,000.0	0.0	100.0
Дүн			73,388,055.4	53,579,289.6	19,808,765.8	73.0

Судалгааны үр дүн, нөхцөл байдал

Тайлант хугацааны төсвийн зарцуулалтын талаарх судалгааны үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

1. Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:

Засгийн газрын 2025 оны “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 7 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар орон тоог 9.0 хувиар бууруулж, баталснаар тус яам 99 орон тоог 9-өөр бууруулан ажилласан байна. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны Б/117 дугаар тушаалын дагуу 7 дугаар сард 90, 8 дугаар сард 88, 9 дүгээр сард 89, 10 дугаар сард 88, 11 дүгээр сард 82, 12 дугаар сард 86 орон тоотойгоор ажилласан байна. Цалингийн сан 3,989,440.2 мянган төгрөгөөр баталснаас 98.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнаж, 63,068,654.32 төгрөгийг хэмнэсэн байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны Б/101 дүгээр тушаалаар 12 дугаар сард хоолны хөнгөлөлтийг 24.0 мянган төгрөгөөр тогтоосныг 2025 оны Б/209 дүгээр тушаалаар 12 дугаар сард 10.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 34.0 мянган төгрөгөөр тогтоон олгосон байна.

3. Гадаад томилолт, арга хэмжээний судалгааны талаар:

Гадаад албан томилолт, арга хэмжээнд хөрөнгө зарцуулаагүй бөгөөд дотоод албан томилолтод 1-6 дугаар сард 49,686.0 мянган төгрөг, 7-12 дугаар сард 1 удаагийн томилолтоор 3,496.0 мянган төгрөг, нийт 53,182.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. Сургалт, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:

Тайлант онд сургалтад 11,878.2 мянган төгрөг, хурал, зөвлөгөөнд 12,036.3 мянган төгрөг, нийт 23,914.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

Сургалтад:

- Улсын байцаагчдыг чадавхжуулах, авлигын эсрэг, хууль эрхзүй, салбарын ёс зүйн дэд хороог чадавхжуулах, худалдан авах ажиллагааны зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой сургалтад 6,716.0 мянган төгрөг, салбарын чиг үүргээс гадна үерийн эрсдэлийн үнэлгээ, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, мэргэжил олгох зэрэг сургалтад 682.2 мянган төгрөг, мөн Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 02 дугаартай тушаалаар 2 албан хаагчийн Хэнтий, Дорнод, Говь-Алтай, Ховд аймаг руу томилолтын зардалд 4,480.0 мянган төгрөг буюу нийт 5,162.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хурал, зөвлөгөөнд:

- Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 3 дугаар тэмдэглэлээр "Бүсийн зөвлөлүүдийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан хурал зохион байгуулах" үүрэг даалгавраар Дорноговь, Архангай аймагт томилолтод 8,042.1 мянган төгрөг,

"Барилгачдын зөвлөгөөн-2025"-ыг Сүхбаатар, Хэнтий, Өвөрхангай аймагт зохион байгуулсан томилолтод 3,744.2 мянган төгрөг, Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг Дархан-Уул аймагт зохион байгуулахад 250.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн талаар:

Тайлант хугацаанд хэвлэл мэдээллийн нэг ч байгууллагатай гэрээ байгуулаагүй, зар сурталчилгаа хийлгээгүй байна.

6.Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардлын талаар:

Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй бөгөөд өмнөх оны аудитаар хохирлыг барагдуулахаар тогтоосон төлбөрийн актыг тайлант оны аудитын явцад барагдуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц сангаас 872,033.1 мянган төгрөг, Герман улсын Пфайфер, Эмит компанийн гүйцэтгэлийн баталгааны хөрөнгийн валютын данснаас 172,387.7 мянган төгрөг, нийт 1,045,493.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, төсөл хэрэгжүүлэгч Бэрэн групп ХХК болон Цагаан хуаран консалтинг ХХК-тай холбоотой “Дамжуулан зээлдүүлэх гэрээ”-ний зээлийн эргэн төлөлтийн маргаан шийдвэрлэх арбитрын ажиллагааны зардалд 872,033.1 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардлаар, Пфайфер компаниас импортолсон тоног төхөөрөмжүүдийн гаалийн бүрдүүлэлт, татварын зардалд 172,847.7 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас зарцуулж, зарцуулагдаагүй 612.8 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэн, Сангийн яамны Төрийн сангийн газартай тооцоо нийлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70202 - Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага /Засгийн газрын нөөц сан/					
1	81101 Засгийн газрын нөөц хөрөнгө	1,045,493.6	1,044,880.8	612.8	99.9
	Дүн	1,045,493.6	1,044,880.8	612.8	99.9

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан төсвийн хөрөнгөөр байгууллагын бусад үйл ажиллагааг хангахад нийт 164,688.3 мянган төгрөгийн бараа, үйлчилгээг нийлүүлснээс шууд худалдан авах аргаар бичиг хэргийн зардалд 42,656.2 мянган төгрөг, тавилга, эд хогшил, өрөөний засварт 38,150.4 мянган төгрөг, шатахуун сэлбэг хэрэгсэлд 7,982.6 мянган төгрөгийг, цахим дэлгүүрээс лиценз, программын сунгалтад 48,636.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны Хот байгуулалт, барилга, орон сууцжуулатын яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой үндсэн хөрөнгө, бараа материалыг давхардуулан дугаарлаж бүртгэсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитор Г.Батбилэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер В.Эрдэнэцогт, дараагийн шатны хяналтыг газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 2/295 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.0 хувиар буюу 138,455.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тайлант оны үр дүнгийн тайлангийн зардал өмнөх оноос 36,666,533.8 мянган төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлттэй байгаа тул материаллаг байдлын түвшнийг шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэх үе шатанд 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 50,512,040.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 505,120.4 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшнийг хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус яамны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн тодотголоор хүргүүлсэн зарим зардлыг танаж баталсан бөгөөд тайлангийн хугацаанд сургалтыг танхим, цахим хэлбэрээр хослуулан зохион байгуулсан, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, томилолт, зочны зардал, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас гэх мэт зардлуудыг батлагдсан төсвөөс хэмнэж зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 90 ажил гүйлгээний 104,564,512.6 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг хугацаанд нь бүрэн, ил тод байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайланд аудит хийж горим сорил хэрэгжүүлэн, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн 830,618.7 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 3 албан шаардлагын биелэлт 100.0 хувь, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийн биелэлт 98.1 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	190,028.4	2	190,028.4	100.0
Албан шаардлага	3	576,223.9	3	576,223.9	100.0
Зөвлөмж	4	64,366.4	4	60,731.8	94.3
Нийт дүн	9	830,618.7	8	826,984.1	98.1

Аудитын явцад Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар төрийн албанаас чөлөөлөн, нөхөн төлбөр олгосон шийдвэрээ хүчингүй болгосонд тогтоосон төлбөрийн актыг барагдуулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын 2025 оны 24 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2025 оны 04 дүгээр албан даалгаврын хүрээнд хийгдсэн зохион байгуулалтаар барилга хот байгуулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа төслүүдийн хөрөнгө, Сангийн сайдын 2025 оны 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам-ын дагуу тус яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжиж ирж байгаа тул хөрөнгийн шийдвэр, хүлээлцсэн акт зэргийг үндэслэн нягтлан бодох бүртгэлд бүрэн, үнэн зөв тусгасан эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 232,419.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 935.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 103,639.2 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 127,845.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 232,419.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 273,714.7 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд зохион байгуулсан уулзалтын зардлаас 260.0 мянган төгрөгөөр согтууруулах төрлийн хүнсний бүтээгдэхүүн, төрийн нарийн бичгийн даргын 10, 11, 12 дугаар сарын дата эрхийн төлбөрт 90.0 мянган төгрөг, 11 албан тушаалтны тоон гарын үсэгт 585.0 мянган төгрөг, нийт 935.0 мянган төгрөгийн төлбөрийг төсвөөс төлж, үрэлгэн зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвөөс үрэлгэн зарцуулсан 935.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори нь Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын харьяа байгууллага бөгөөд улсын төсвөөс санхүүжилт авахгүй, өөрийн орлогоос санхүүждэг. Гэтэл 2025 онд Барилга хөгжлийн төв ТӨҮГ нь тус яамны төрийн нарийн бичгийн даргатай 240,000.0 мянган төгрөгийн "Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг гүйцэтгүүлж, санхүүжилт олгох гэрээ" байгуулж, гүйцэтгэлээр тус яамны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын төсвөөс 83,310.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх;

2. Дотоод албан томилолтын болон шатахууны анхан шатны баримт дутуу 3,511.0 мянган төгрөг, и-баримтгүй, баримтын иж бүрдлийн шаардлага хангаагүй 7,193.9 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6.-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны

баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримт дутуу, иж бүрдлийн шаардлага хангаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх;

3. Тайлант онд хамтын ажиллагааг өргөжүүлэхээр гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын болон салбарын байцаагчдад зориулсан сургалтын зардлаас ресторанд 6,029.6 мянган төгрөг, бусад зардалд 144.7 мянган төгрөг, нийт 6,174.3 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэх;

4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23, А/82 дугаар тушаалаар спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардалд төсвөөс 3,450.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх;

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 24 нэр төрлийн 269 ширхэг, 125,358.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулан дугаарлаж бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг давхар дугаарлаж, буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын журналд 5 нэр төрлийн 13 ширхэг, 2,486.5 мянган төгрөгийн бараа материалыг давхардуулан дугаарлаж бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 5.1.5-д "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг давхар дугаарлаж, буруу бүргэсэн зөрчлийг арилгаж, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ХББОСЯ-ны уулзалтын зардлаас 260.0 мянган төгрөгөөр спирт согтууруулах хүнсний бүтээгдэхүүн, төрийн нарийн бичгийн даргын 10, 11, 12 саруудын дата эрхийн төлбөрт 90.0 мянган төгрөг, 11 албан тушаалтны тоон гарын үсэгт 585.0 мянган төгрөг, нийт 935.0 мянган төгрөгийн төлбөрийг төсвөөс төлж, үрэлгэн зарцуулсан.	1	935.0	1	935.0									
Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори нь Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын харьяа байгууллага бөгөөд улсын төсвөөс санхүүжилт авахгүй, өөрийн орлогоос санхүүждэг. Гэтэл 2025 онд Барилга хөгжлийн төв ТӨҮГ нь тус яамны төрийн нарийн бичгийн даргатай 240,000.0 мянган төгрөгийн "Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг гүйцэтгүүлж, санхүүжилт олгох гэрээ" байгуулж, гүйцэтгэлээр ХББОСЯ-ны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын төсвөөс 83,310.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож зориулалт бус зарцуулсан.	1	83,310.0			1	83,310.0							
Дотоод албан томилолтын зардлаас буудлын болон шатахууны анхан шатны баримт дутуу 3,511.0 мянган төгрөг, и-баримтгүй, баримтын иж бүрдлийн шаардлага хангаагүй 7,193.9 мянган төгрөгийг зарцуулсан.	1	10,704.9			1	10,704.9							
Хамтын ажиллагааг өргөжүүлэхээр гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын болон салбарын байцаагчдад зориулсан сургалтын зардлаас ресторанд 6,029.6 мянган төгрөг, бусад зардалд 144.7 мянган төгрөг, нийт 6,174.3 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.	1	6,174.3			1	6,174.3							

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23, А/82 дугаар тушаалаар спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардалд төсвөөс 3,450.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	3,450.0			1	3,450.0						
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 24 нэр төрлийн 269 ширхэг, 125,358.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг давхардуулан дугаарлаж бүртгэсэн.	1	125,358.7					1	125,358.7				
Бараа материалын журналд 5 нэр төрлийн 13 ширхэг, 2,486.5 мянган төгрөгийн бараа материалыг давхардуулан дугаарлаж бүртгэсэн.	1	2,486.5					1	2,486.5				
Дүн	7	232,419.4	1	935.0	4	103,639.2	2	127,845.2				



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 44/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/259/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уулзалтын зардлаас 260,000.00 /хоёр зуун жаран мянган/ төгрөгөөр согтууруулах төрлийн хүнсний бүтээгдэхүүн, Төрийн нарийн бичгийн даргын 10, 11, 12 дугаар сарын дата эрхийн төлбөрт 90,000.00 /ерэн мянган/ төгрөг, 11 албан тушаалтны тоон гарын үсэгт 585,000.00 /таван зуун наян мянган/ төгрөг, нийт 935,000.00 /есөн зуун гучин таван мянган/ төгрөгийн төлбөрийг төсвөөс төлж, үр ашиггүй зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын төсвөөс үрэлгэн зарцуулсан 935,000.00 /есөн зуун гучин таван мянга/ төгрөгийг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баяраагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/, нягтлан бодогч /Ж.Өлзийжаргал/ нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Б.ДОЛГОРЖАВ
Г.БАТБИЛЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

177 /АД160070

Улаанбаатар хот

САГ-2026/259/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори нь Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ын харьяа байгууллага бөгөөд улсын төсвөөс санхүүжилт авахгүй, өөрийн орлогоос санхүүждэг. Гэтэл 2025 онд Барилга хөгжлийн төв ТӨҮГ нь тус яамны Төрийн нарийн бичгийн даргатай 240,000,000.00 /хоёр зуун дөчин сая/ төгрөгийн "Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааг гүйцэтгүүлж, санхүүжилт олгох гэрээ" байгуулж, гүйцэтгэлээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлын төсвөөс 83,310,000.00 /наян гурван сая гурван зуун арван мянган/ төгрөгийн санхүүжилт олгож зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж тус тус заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/, нягтлан бодогч /Ж.Өлзийжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Б.ДОЛГОРЖАВ
Р.БАТБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-764230

Z:\Alban Shaardlaga\2026\0125_SAG-2.Docx

1526180428



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 08 сарын 25 өдөр

Дугаар

176/А0160070

Улаанбаатар хот

САГ-2026/259/НА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод албан томилолтын болон шатахууны анхан шатны баримт дутуу 3,511,000.00 /гурван сая таван зуун арван нэгэн мянган/ төгрөг, и-баримтгүй, баримтын иж бүрдлийн шаардлага хангаагүй 7,193,919.00 /долоон сая нэг зуун ерэн гурван мянга есөн зуун арван ес/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6.-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйл акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримт дутуу, иж бүрдлийн шаардлага хангаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/, нягтлан бодогч /Ж.Өлзийжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Б.ДОЛГОРЖАВ
Г.БАТБИЛЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 175/А016 0070

Улаанбаатар хот

САГ - 2026/259/НА-СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хамтын ажиллагааг өргөжүүлэхээр гадаадын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтын болон салбарын байцаагчдад зориулсан сургалтын зардлаас ресторанд 6,029,624.00 /зургаан сая хорин есөн мянга зургаан зуун хорин дөрвөн/ төгрөг, бусад зардалд 144,700.00 /нэг зуун дөчин дөрвөн мянга долоон зуун/ төгрөг, нийт 6,174,324.00 /зургаан сая нэг зуун далан дөрвөн мянга гурван зуун хорин дөрвөн/ төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасантай тус тус нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/, нягтлан бодогч /Ж.Өлзийжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Б.ДОЛГОРЖАВ
Г.БАТБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-2.Docx

1526180434



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 178/А-016 0070

Улаанбаатар хот

САГ-2026/259/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны 2025 оны тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/23, А/82 дугаар тушаалаар спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулах арга хэмжээний зардалд төсвөөс 3,450,000.00 /гурван сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-т “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/, нягтлан бодогч /Ж.Өлзийжаргал/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Б.ДОЛГОРЖАВ
Г.БАТБИЛЭГ